



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/367

Чойбалсан

Г

Эрх шилжүүлэх тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 60. дугаар зүйлийн 60.1.1, 68 дугаар зүйлийн 68.3, 68.4, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 3.3.1, 8.2 дугаар зүйлийн 10.13-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төвийн болон сумын нутаг дэвсгэрт байрлах нийтийн эзэмшлийн зам, талбайд стандартын шаардлага хангасан худалдаа, үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгжид ашиглуулах талбайн зөвшөөрөл олгох эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1-т заасны дагуу Сумын засаг дарга нарт шилжүүлсүгэй.

2.Эрх шилжүүлсэн чиг үүргийг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг Сумын засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁЛ